



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/298

Алтай хот

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газрын тухай хуульд нийцээгүй газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмыг зөрчин гаргасан "Монцулхир" ХХК-ийн 50 айлын орон сууцны зориулалттай 678 м2 газрыг эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын 2020 оны А/318 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 8208004699 нэгж талбарын дугаартай, 000016225 газар эзэмших эрхийг гэрчилгээг хүчингүй болгон 10 хоногийн дотор албан ёсоор эрх цуцлагдсан мэдэгдлийг хүргүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ц.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

